

Эдийн засгийг эмчлэх "жор"-ыг баталлаа
Гишүүд эдийн засгийн хямралаас гарахын тулд шийдэмгий алхам хийжээс аргагүй. > 2

Дэлхийн шинэ дэг: "Хельсинк", Балтик, Арктик
Оросуудын хувьд Балтик бол хамгийн эмзэг, аюул дагуулах орон зай. > 4

Гаррэт Вилсон: Би ургамал, ногоо тарих дуртай
Монголын уран бүтээлчид дэндүү хямд тасалбараар гайхалтай үзүүлбэр үзүүлдэг. > 6



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2016.11.28, ДАВАА ~ №246 (524)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 16 настнуудын андгай өргөх ёслолд оролцов.
Улсын төсвөөс 2017 онд шинжлэх ухааны салбарт 27 тэрбум төгрөг зарцуулна.
АН-ын Үүрийн дарга нар Их хурлыг зохион байгуулах ажлын хэсэгт шаардлага хүргүүлжээ.
Эхийн сүү орлуулах бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулахаа салбарын сайд хэлэв.
Улс тунхагласан өдрөөр эрдэмтэд анхдугаар Үндсэн хууль ба засаглалын талаар хэлэлцэв.

ЭДИЙН ЗАСАГ
Аравдугаар сарын байдлаар 25.4 тэрбум төгрөгийн буцаан олголт өгөхөөр байна.
"Rio Tinto" ирэх таван жилд бэлэн мөнгөний урсгалаа таван тэрбум ам.доллараар нэмнэ.
Хөрөнгийн биржийн индекс 785.32 нэгж болж, 1.08 хувиар өсөв.
Монголбанкны Ерөнхийлөгч Зүүн өмнөд Азийн төв банкуудын холбооны ерөнхийлөгчдийн уулзалтад оролцож байна.
Банк бус санхүүгийн байгууллагын нийт актив 724.2 тэрбум төгрөгт хүрэв.

НИЙГЭМ
Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт ирэх онд 27 тэрбум төгрөг төсөвлөжээ.
Замын халтиргаа, гулгааг арилгах 189 тонн давс, 597 тонн давсны нөөц байна.
Дорнод аймагт ул мэдэгдэх шингэн ууж 21 хүн хордсоноос тав нь нас баржээ.
Сургууль, цэцэрлэгүүдийн аюулгүй байдлын талаар үндэсний бодлогын талаар чуулна.

ДЭЛХИЙ
Кубийн домогт удирдагч Фидель Кастро 90 насандаа таалал төгслөө.
Израйльд санаатай тавьсан түймрийн улмаас 75 мянган хүнийг нүүлгэн шилжүүлэв.
Сирид ISIS бүлэг химийн эвсэг ашигласан шинж тэмдэг илэрсэн байна.
АНУ-ын Чикаго хотод буудалцааны улмаас нэг хүн амь үрэгдэж, найман хүн шархдав.
Тажикстаны Каракул хотын орчимд 4.5 магнитудын хүчтэй газар хөдөлжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2016.11.28

-16° | **-14°**

БАГА ЗЭРГИЙН ЦАС ОРНО

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭЖИГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУГУУС УНИШНА УУ.

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Ипотекийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ



Монголбанкнаас зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор энэ сард багтан хамгийн багадаа 20 орчим тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр зээл гарахыг хүлээж буй иргэд шинэ онтой уралдан нүүдэл хийнэ гэсэн үг. >11

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН Суурийг нь сэлгэх цаг болжээ

Б.Гандолгор
@gandolgorZGM

Олон нийтийг хамардаг, амьсгалаар тархах өндөр эрсдэлтэй учраас цагаан тахал болгоомжлохоос аргагүй өвчнүүдийн нэг. Социалист нийгмийн үед эмнэлгийг нь хүртэл хөл хөдөлгөөнтэй газраас зайдуу байлгадаг байлаа. Насанд хүрэгчдийн уушгины сүрьеэгийн эмнэлэг Зайсангийн аманд байрлаж байсан бол хүүхдийнх нь Дарь-Эх рүү гээд зааг ялгаатай

орчинд тусгаарлан эмчилж байв. Харин 2000 оны үед Сүрьеэгийн клиникийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн харьяа болгож, хашаан дотор нь байлгахад шийдвэрлэсэн. Энэ цагаас хойш сүрьеэгийн эмнэлэг олон хөлийн газартай хаяа нийлэх болов. Олон хөлийн гэж тодотгосны учир нь "Нарантуул" захтай залгаа оршдогоос тэр.

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭДИЙН ЗАСАГ Эдийн засаг ёроолын цэгтээ хүрсэн байж мэднэ

Ирэх улирлуудад эдийн засаг сэргэнэ гэж хэрэглэгчид үзэж байна

Г.Байгал
@baigalZGM

МУИС-ийн багш, дэд профессор, эдийн засагч Б.Алтанцэцэгтэй ярилцлаа.

-Олон улсын үнэлгээний "Moody's", "Fitch" агентлаг Монгол Улсын Засгийн газрын зээлжих зэрэглэлийг таналаа. Сангийн яам, Монголбанкнаас үүнтэй санал нийлэхгүй гэдгээ мэдэгдсэн. Та санал нийлэх үү? >11

FT А.Меркель мөрийн хөтөлбөр болохуйц үг хэллээ

FINANCIAL TIMES

Стефан Вагстил
Германы канцлер Ангела Меркель дөрөв дэх удаагаа сонгуульд өрсөлдөхөө зарлахдаа "Герман улс хэзээ ч ийм сайн нөхцөлд байгаагүй" хэмээн онцолжээ. Улмаар нээлттэй байдал, чөлөөт худалдааны төлөө тэмцэж, популизмыг сөрөхөө амалсан юм.

Хатагтай Меркель тус улс тусгаарлах үзлийг эсэргүүцэх хэрэгтэй гээд АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Номхон далайн түншлэлээс татгалзаж байгааг шүүмжилсэн юм. Тэрбээр парламентад хэлсэн үгэндээ цагаачлал, даяарчлал болон терроризмээс эмзэг үзэгдлийг

даван туулах асуудлыг хөндсөн байна. Канцлер "Бид үүний төлөө хамтдаа зогсох ёстой. Олон талт харилцаа, даяарчлалыг бүтээхийн төлөө бусад улс хамтрах ёстой ба би үүний төлөө тэмцэнэ" хэмээн мэдэгдсэн. Энэ нь сонгуулийн өмнөх уриа мэт сонсогдсоныг ажиглагчид тэмдэглэж байна.


АНУ-ын сонгуульд ноён Трамп ялсны дараа хатагтай Меркель Британийг Брексит рүү түлхэж, Европын орнуудад газар авч буй популизмын эсрэг либерал үзлийн гол төлөөлөгч болж байгаа юм.

>9

MSE ALL 785.32 1.08%	АЛТ 1186 0.16%	ЗЭС 5879 0.19%	10-ЧИНГИС БОНД 87.640 0.06%	5-ЧИНГИС БОНД 95.930 0.09%	АМ.ДОЛЛАР 2459.66	ЮАНЬ 355.47	РУБЛЬ 38.08
-----------------------------------	-----------------------------	-----------------------------	--	---	-----------------------------	-----------------------	-----------------------

Эдийн засаг

MSE ALL индекс нэг хувиар өслөө



MSE ALL индекс сүүлийн нэг сард (нэгжээр)

Монголын хөрөнгийн биржийн жишиг индекс MSE ALL индекс нэг хувиар өсөж, 785.32 нэгжид хүрлээ. Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагийн байдлаар Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1.3 их наяд төгрөгтэй тэнцсэн байна. “I”, “II” болон “III” ангилалд бүртгэлтэй 16 хувьцаат компанийн 12126 ширхэг хувьцаа арилжсан. Нийт 18 сая төгрөгийн гүйлгээ хийжээ. Есөн хувьцаат компанийн

хувьцааны ханш өссөн.

Дөрвөн компанийн хувьцааны үнэ буурчээ. Мөн гурван компанийн хувьцааны ханш тогтвортой байлаа. Ялангуяа, “Ноёт хайрхан” компанийн үнэт цаасны ханш хамгийн өндөр өсөв. Хувьцааны ханш нь 14.93 хувиар дээшилжээ.

Мөн “Газар сүлжмэл” компанийн хувьцааны ханш 14.3, “Говь”-ийнх 8.9 хувиар тус тус өслөө. [ЗГМ]



ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	61.76	▲ +2.42%	11/25/2016
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.019	▼ -5%	11/24/2016
PETRO MATAD	MATD	LON	GBX	5.4	▲ +16.76%	11/26/2016
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.033	▲ +3.03%	11/25/2016
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	11/24/2016
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.4	▲ +7.94%	11/26/2016
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.81	▼ -2.24%	11/26/2016
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.325	▼ -1.52%	11/26/2016
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.22	▼ -4.55%	11/25/2016
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.435	▲ +3.57%	11/26/2016

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1183.56	▲ +0.15%	11/26/2016
ЦАГААН АЛТ	PLA	унци	908.1	▼ -2.45%	11/26/2016
МӨНГӨ	SIA	унци	16.585	▲ +0.42%	11/26/2016
ЗЭС (COMEX)	HGA	фунт	268.15	▼ -63.46%	11/26/2016
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	71.81	▲ +0.83%	11/25/2016
WPI ТОС	CLA	баррель	46.06	▼ -3.96%	11/26/2016
БРЕНТ	COA	баррель	47.24	▼ -53.55%	11/26/2016
БЕНЗИН	XBA		137.27	▲ +3193.07%	11/26/2016
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.071	▲ +1.95%	11/26/2016
НҮҮРС (NYMEX)	OZA	тонн	40	▼ -1.23%	11/24/2016
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	92.5	▲ +6361.95%	11/26/2016
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.198	▲ +1.33%	11/26/2016
БУДАА	RRA	центнер	9.625	▲ +39.09%	11/26/2016
БУУДАЙ	WA	бушель	419.5	▼ -1%	11/26/2016
КАКАО	CCA	тонн	2415	▲ +274.25%	11/26/2016
КОФЕ	KCA	фунт	1.55	▲ +211.11%	11/26/2016

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
ГОВЬ ХК	GOV	10400	▲ 8.90 %	11/27/2016
СҮҮ ХК	SUU	133.74	▲ 4.51 %	11/27/2016
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	18000	▲ 2.27 %	11/27/2016
АТАР-ӨРГӨӨ ХК	ATR	62000	◀▶ 0.00 %	11/27/2016
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	40000	◀▶ 0.00 %	11/27/2016
МАТЕРИАЛИМПЕКС ХК	MIE	8000	▼ -1.23 %	11/27/2016
МОНГОЛ НЭХМЭД ХК	MNH	5090	▼ -7.45 %	11/27/2016
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	302.86	▲ 2.10 %	11/27/2016
РЕМИКОН ХК	RMC	51	▲ 2.00 %	11/27/2016
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2872	▼ -4.27 %	11/27/2016
ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ ХК	SUL	35000	▲ 14.38 %	11/27/2016
ТАВАН ТОЛГОЙ ХК	TTL	2566	▲ 2.93 %	11/27/2016
ТҮШИГ УУЛ ХК	TUS	423.1	▲ 5.78 %	11/27/2016

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5398.92	+18.24	▲ +0.34%	11/26/2016
DAX INDEX	DAX	10699.27	+10.01	▲ +0.09%	11/26/2016
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15075.44	+0.24	◀▶ 0.00%	11/26/2016
S&P/ASX 200	AS51	5507.785	+22.71	▲ +0.41%	11/25/2016
S&P 500	INX	2213.35	+8.63	▲ +0.39%	11/26/2016
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3261.938	+20.2	▲ +0.62%	11/25/2016
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	19152.14	+68.96	▲ +0.36%	11/26/2016
TOP 20	MSETOP	10993.93	+176.14	▲ +1.63%	11/24/2016
FTSE 100	UKX	6840.75	+11.55	▲ +0.17%	11/26/2016
HANG SENG	HSI	22723.45	+114.96	▲ +0.51%	11/25/2016
NIKKEI 225	NKY	18381.22	+47.81	▲ +0.26%	11/25/2016

АМЕРИК ХЭРХЭН АЖИЛДАГ ВЭ?

Bloomberg TV MONGOLIA

"Америк хэрхэн ажилладаг вэ" цуврал нэвтрүүлгээр Америк гэх их гүрний цөмд аваачиж, энэ орныг хөдөлгөдөг нүдэнд ил харагддаггүй ажиллагаануудын нууцыг нээдэг. Харин нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт Америк орны эрчим хүчний аварга том машин улсынхаа хэрэглээг хэрхэн хангаж, амьдрах эх үүсвэрээр тэтгэж байдаг талаар хүргэх болно. Түүнчлэн эрчим хүч хаанаас үүсэлтэй, хэрхэн ашиглагддаг, үүнийг хэрхэн үргүй зарцуулдаг, айл өрх, албан байр бүрт хэрхэн нийлүүлдэг талаар хүлээн авч үзээрэй.

Пүрэв гараг /2016.12.01/

22:00

07:00/14:00 Баасан гараг /давталт/

11:00 Бямба гараг /давталт/

20:00 Ням гараг /давталт/